



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А/822.

Зуунмод

Агентлаг, харьяа байгууллагын 2023 оны
жилийн эцсийн үйл ажиллагааны
үр дүнгийн тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.1, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 2.2, аймгийн Засаг даргын 2022 оны А/300 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 10.1.2, 12.1 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Байгууллагын 2023 оны үйл ажиллагааны үр дүнгийн жилийн эцсийн үнэлгээг хавсралтаар баталсугай.

2.Үйл ажиллагаагаа оновчтой зохион байгуулж, үр дүнд хүргэн 2023 оны ажлаараа шалгарч, үндсэн чиг үүргээ шаардлагын өндөр түвшинд хэрэгжүүлж, шилдэг агентлагаар шалгарсан Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Татварын хэлтэс, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Цагдаагийн газар, аймгийн Нэгдсэн эмнэлгийн хамт олонд дурсгалын цом, батламж хадгалуулсугай.

3.Байгууллагын 2023 оны жилийн эцсийн ажлын гүйцэтгэл, үр дүн, Төсвийн шууд захирагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг маш сайн үнэлгээтэй дүгнүүлсэн байгууллагын дарга, эрхлэгч нарыг үндсэн цалингийн 50 хүртэлх хувиар, байгууллагынхаа төсөвт багтаан шагнаж урамшуулахыг зөвшөөрсүгэй.

4.Салбартаа хийж хэрэгжүүлж буй ажлуудыг иргэдэд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр тогтмол тайлагнаж ажиллахыг төсөвт байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга (Т.Хуягбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

Аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар
сарын 22 -ны өдрийн 4/1822 дүгээр
захирамжийн хавсралт

Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, харьяа байгууллагын 2023 оны жилийн эцсийн дүн

2023.12.19

[illegible]

НАСАНИХ

УВААДТ ПИИЖИЛСЭ УХЭЛСЭНИЙ ХЭЛТЭСНИЙ ДАРГА

ИЗДАТЕЛЬСТВО

ХЯНАЛТ-ШИИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН. Б.МОНХБАТ

005909
H0A00590909